

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГ

### Намсрай Довдончулуу

Он сар өдөр, төрсөн газар	1921, Дундговь аймгийн Дэрэн сум
Үндсэн сүм хийд	Бэлийн жас
Б.Ринченгийн сүм, хийдийн нэр	Бэлийн хурал
Ярилцлаганд дурдагдсан бусад сүм хийдүүд	Жадамбын жас, Тэгшийн жас, Дарь эхийн хийд



#### - Биеэр очиж үзсэн үү?

Би хурал хурж байхад Тэгш дээр нь бол очиж байгаагүй. Хаагдсаны дараа нь очиж байсан. Энэ бэлийн энд рүү байсан байх.

#### - Энэний талаар сайн мэдэх үү?

Хэдэн онд байгуулагдсаныг бол хэлж чадахгүй. Тэгэхдээ өөрөө нэг арваад наснаасаа л хойш л суусан байх Тэгээд хаагдахад нь хаагдаад өнгөрсөн.

#### - Хэдэн дугантай байсан бэ?

Гонгор гээд жижиг байшин тэр нэг хоёр арай том модон дуганатай байсан юм. Цогчингийн дуган, Хайлангийн дуган гээд арай хоёр том дуган байсан.

Энэний нэр Дагданпунцоглин гэдэг байсан. Ерөнхий нэр нь. Тэгээд дотроо нэг бол Цогчин дуган гээд ерөнхий юм даа. Хайлан гээд дуган бий. Нэг нь Нүгнээ гээд байсан юм. Нэг нь Дарь эхийх гээд байсан юм. Ийм дөрвөн дуган байсан.

#### - Хуучин суварга байсан уу?

Хуучин суварга байгаагүй.

#### - Одоо бригадад байгаа суварга аль дуганы сууринд байгаа вэ?

Цогчин дуганы суурин дээр байсан.

#### - Хайлангийн дуган Цогчин дуганы аль талд байсан бэ?

Суварганы баруун талд нь байсан. Зүүн талд нь Цогчин дуган байсан. Том дуганы хойд талд Дарь эх дуган байсан.

#### - Том гэр байсан уу?

Том гэр байгаагүй. Зүгээр нэг 4 ханатай гэр л байсан байх. Нүгнээ сахихаараа яадаг байсан л даа...

#### - Цогчин дуганы зүүн хойно том гэр байсан байж мэдэхээр суурь байх юм. Чулуун суурь.

#### Тэнд юу байсан юм бол ?

Тэр бол тийм байгаагүй.

#### - Зүгээр энгийн гэрүүд байсан уу?

Энгийн гэр гэж айлын гэрүүд үү? Зөндөө нэлээд бий.

#### - Хэдэн ламтай байсан бэ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГ

Зуу жаахан гаран байсан байх аа. 10 лам болоод би лам хийгээгүй шүү дээ.

**- Та хэдэн онд төрсөн бэ?**

1921 онд

**- Нэр нь?**

Намсрайн Догдончадва.

**- Хийдийн толгой лам хэн байсан бэ?**

Хамгийн сүүлийнх нь Өндөр даянч Наваан гэж гавж байсан. Тэр хүн суугаад удаагүй ээ . нэг жил ч болоогүй татагдаад явсан юм. Түрүүнд нь Дашнаваан гэж хүн байсан.

Түрүүнд нь хоёр лам байсан гэдэг юм билээ.

**- Зоч лам байсан уу? Лүйжин тавьдаг лам нар?**

Байсан. Одоо Човхроо, тэр хойно Банзар байгаа нь тэр дээ. Банзрай нь одоо алга шив дээ.

Тэгэхдээ бол шинэхэн тэр зочийн хурал нь бол байгаагүй. Энэ хойно Пунцог зоч гуай гэж хүн зочийн хурал байгуулах санаатай байсан юм билээ. Тэгээд амжаагүй.

**- Зоч лам нь тусдаа дугантай байсан уу?**

Байхгүй. Зүгээр хоёр байшинтай.

**- Байшин нь хаана байсан юм?**

Байшин нь одоо тэр Адьяа Сангийн буудал гээд тэнд байсан.

**- Аль зүгт байсан вэ?**

Энэ баруун хойно. Хөвдтэй гээд шагай харавдаг газар байсан даа... Тэрний дэргэд байсан. Тэгээд энэ намар нэг зоч нар чинь жарз хийх гээд явдаг юм байна шүү дээ. Тэгээд намарт нэг наадам болж байгаа юм шиг .Жарзанц явсан улсууд нь ирээд.

**- Тахидаг овоо хаагуур байна вэ?**

Саруулын тахилгат гэдэг өндөр овоо.

**- Майдар эргэдэг байсан уу?**

Майдар эргэдэг байсан.

**- Аль улиралд эргэдэг байсан бэ?**

Зун намрын зааг дээр намар тийшээ л эргэдэг байсан байхаа.

**- Ганжуур байсан уу?**

Хоёр ганжуур байсан

**- Ганжуур эргэдэг байсан уу?**

Ганжуур эргэнэ гэдэг чинь ганжуур ачаад явахыг хэлж байгаа биз дээ. Би сайн мэдэхгүй юм байна.

**- Хийдийн гол сахиус ямар сахиус байсан бэ?**

Гомбо Жамсран байсан гэж үздэг.

**- Сарын дүйцэн өдрүүдээр ямар хурал хурдаг байсан бэ?**

14 гээд 15-нд сар болгон хааяа нэг цуглаж хурдаг. 29-нд нэг цуглаж хурдаг. Нүгнээ, Хайлан хоёр удаан байнга хурдаг байсан. Нүгнээ бол хавар зуны сарын шинийн нэгэн. Хайлан ч яахав намар байдаг байсан.

**- Сор залдаг байсан уу? Галын тахилга болдог байсан уу?**

Сор уу, болно. Жасынхан юу болбол өвлийн адаг сарын 29-нд тогтмол сор зална. Зүгээр түр зуурын улсуудын сорыг залахаар болвол хийдэг л байсан.

**- Цагаан сарын хурал хурдаг байсан уу?**

Тийм ээ, тогтмолдоо хурдаг байсан.

**- Гавж нар их байсан уу?**

Гавж нар ч одоо түрүүч нь үхсэн байсан. Сүүлчийн улсуудыг бодоод үзье. Таван хүн байсан юм уу даа.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГ

### - Нэрсийг нь мэдэх үү?

Ай даа, ороолдоод үзье. Их бага хоёр даяанч байсан. Нэг нь Наваангончог, нөгөөх нь хэн ч билээ... Лувсандорж, Ишбалжар.

### - Гэлэн лам нар хэд орчим байсан бэ?

Ээ дээ тэрнийг ч би барахгүй. Хэдэн гэлэн байх нь ч байсан.

### - Олон байсан уу?

Арваадхан байсан юм болов уу...

### - Оточ лам нар байсан уу? Маарамба?

Тийм цол авсан маарамба байгаагүй байх аа. Эм барьдаг ганц нэг байсан.

### - Хуучны ямар эд хөрөнгө байсан бэ? Жишээ нь хайч?

Байсан ч юм уу, үгүй ч юм уу, тэрнийг мэдэхгүй.

### - Хуучин айлуудад ямар хайч байсан бэ?

Зүгээр хятад хайч байсан. Одоо тэгэхдээ бүү мэд.

### - Хийд хэдэн онд хаагдсан бэ?

1938 онд хаагдсан.

### - Одоо энэ сум төвд яг адилхан хийд байна. Үүнийг сэргээсэн үү?

Энэний нэрийг тэрэнд өгчихгүй юу... Сэргэхдээ нэргүй болчихоод. Тэгээд зүгээр нэрлэсэн байх. Дэрэнгийн жинхэнэ харъяанд бол хэдэн юм байсан гэсэн... Жадамбын жас, Тэгшийн жас, Бэлийн жас, гээд нэг 4 юм байсан гэсэн.

Би нэг юм сонирхуулж ярья. Дарь эхийн гээд жижиг хийд байсан гэж ярьсан шүү дээ. Тэрнийг Доёд лам гэдэг хүн байгуулсан юм. Тэр хүн ямар утгатай хүн байсан бэ гэхээр, тэр хүн алтан ганжуур бүтээдэг тийм хүн байсан. Одоо энэ хойно нэрэнд байж байгаад. Одоо тэр уул санаа нь бол тэнд хурал байгуулах гэж юм байна лээ л дээ. Даанч тэгээд сүүлд болио биз дээ. Тэгээд энийг байгуулчихсан байгаа юм. Ганцхан Дарь эхийнхийг байгуулсан. Тэгээд ухаандаа Богдоос шагнал аваад шагналын хамба болсон. Тэгээд энэ хурлын хамба биш, тэгээд тийм хүн байсан. Тэгээд хамгийн түрүүнд татагдаад явсан. Тэр ловон байсан Наваантай хамт.

### - Энэ сумын төвд шинэ хийдийг нээхэд хуучин лам байсан өвгөчүүл олон байсан уу?

Мэдэхгүй байна аа. Жанжаа, Гонгор .. Заримыг нь сайн санахгүй байна.

### - Хуучин энэ багадаа Бэлийн жаст сууж байсан хүмүүс байна уу?

Тэр дунд нь хоёр хүн байсан юм шиг байна. Данжаа Дандаа, Аюушжав. Өөр ч хүн байгаагүй байх аа.

### - Та багадаа энэ Бэлийн хуралд лам байсан биз дээ?

Намайг арван долоотой байхад хаагдсан. Тэгээл тэр болтол нь л байсан. Арваадхандаа л лам болсон байх. Нээг их удаагүй ээ. Байнга байгаагүй.

Ярилцсан: М.Жужа, Т.Кристина, О.Энхбаяр